

Хэрэглэгчийн үнэлгээ

Засгийн газрын тогтоол болон аймгийн Засаг даргын баталсан 2007 оны 01 тоот захирамжийн дагуу төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийхдээ иргэд, хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээг харгалзан үзэж байна. Төрийн албаны чанар, үйлчилгээний хүртээмж иргэдийн санаа сэтгэлд хэр нийцэж буйг үнэлэх санал асуулгын хуудас болосруулж 15 сумын 320 иргэнээс үнэлгээ авах ажлыг ЗДТГ-ын ХШҮ-ний тасгаас зохион байгуулж дүгнэлээ. Иргэдээс тухайн суманд Засгийн газрын болон Засаг даргын хөтөлбөр хэрхэн хэрэгжиж байгааг, сумын ЗДТГ, багийн засаг дарга нарын ажилд ямар үнэлгээ өгч буйг, захиргааны болон эмнэлэг, боловсролын байгууллагын үйлчилгээ хэр чанартай, шуурхай, хүртээмжтэй буйг 1-5 онооны /5-маш сайн, 4-сайн, 3-хангалттай, 2-хангалтгүй, 1-маш муу/ үнэлгээгээр авсан. Дүнг нэгтгэж үзэхэд үнэлгээ өгсөн иргэдийн 62,4%- хангалттай, 15,5%-сайн, 12,0%-маш сайн, 10,1% хангалтгүй гэж дүгнэжээ.

Мөн аймгийн ИТХ-ын ажлын алба, ТББ-ын орон тооны бус зөвлөл хамтран аймгийн төвд 172 хүнээс төрийн байгууллагын ажил үйлчилгээний чанар, хүртээмж, цаашид авах арга хэмжээний талаар санал асуулгаар судалгаа хийсэн. Уг санал асуулгад хамрагдсан 101 хүн нь ямар нэгэн асуудлаар төрийн байгууллагад хандаж үйлчилгээ авч, санал хүсэлт гаргасан байна. Үүний 44 хүн буюу 45% нь тавьсан асуудал, санал хүсэлттэй хариулт аваагүй гэж дурьджээ. Орон нутгийн төр захиргааны байгууллагад ажлын цаг ашиглалт муу, ажлаа мэдэхгүй чирэгдүүлэх, шийдвэрлэх чадваргүй ажилтан олон зэрэг дутагдал бйадгийг иргэд тодорхойлсон байна.

Цаашид хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээг хөндлөнгийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр төлөвлөж байна. Гэвч судалгаа шинжилгээний туршлагагүй, боловсон хүчин, материаллаг нөөцгүй, өөрсдийн санаачлагагүй байдал нь ИНБ-даар гүйцэтгүүлэхэд хүндэрэл учруулдаг.

Аймгийн ЗДТГ-аас сумдын 2009 оны ажилд хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөхөд үндсэн 6 үндсэн үзүүлэлтийн нийлбэрийн дундаж үнэлгээгээр 10 сум хангалттай Булган, Өлзийт, Чулуут, Өгийнуур, Хангай зэрэг 9 сум дутагдалтай гэж дүгнэгдэв.

Хэлтэс агентлагуудаас Боловсрол соёлын газар, Биеийн тамир спортын газар “маш сайн” Татварын хэлтэс, Статистикийн хэлтэс, Цагдаагийн хэлтэс, ШШГА, ЭМГ, НДХ, ХХҮХ, МХГ зэрэг 14 байгууллага “сайн”, ХХААЖДҮГ газар, УЦУОШТ, Музей” хангалттай” үнэлгээ авсан

Нутгийн захиргааны байгууллагуудын 2009 оны ажилд хийсэн хяналт шинжилгээгээр сумдын ажил “**хангалттай**”, агентлаг байгууллагын ажил “**Сайн**” гэсэн дүнтэй үнэлэгдлээ.

Энэ онд сум, байгууллагын ажилд хяналт шинжилгээ хийдэг журмаа шинэчлэн боловсруулж мөрдөхөөр төлөвлөж байгаа бөгөөд Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж, төрийн ажлын талаар иргэдийн үнэлгээ, санаа бодлыг судлан дүгнэлт өгөх үйлчилгээг гүйцэтгэхийг дэмжих бодлого барьж байна.

Аймгийн ЗДТГ